

**Боловсрол, соёл, урлагийн газраас 2018 оны 05-р сарын  
эхний долоо хоногт хийгдсэн ажил**

**2018.05.03**

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн долоо хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	“Дэлхийн номын өдөр”-ийг орон нутагт тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайланг ЕБСургуулиудаас авч нэгтгэн БСШУСЯ-д хүргүүлсэн.		
2	05 дугаар сарын 02-ноос 05-ны өдрүүдэд “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг орон нутагт тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гаргаж, түүний дагуу үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Сурагчдын дунд “Түргэн уншлага”-ын уралдаан, сурагчид болон насанд хүрэгчдийн дунд “Сайхан бичигтэн”-ий уралдаан, “Монгол бичгийн гайхамшиг” бүтээлийн үзэсгэлэнг тус тус зохион байгуулсан болно.		
3	ЕБСургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын халаалт, угаалтуур, суултуурын мэдээг авч нэгтгэн БСШУСЯ-д хүргүүлсэн.		
4	9,12-р анги төгсөгчдийн мэдээллийг авч нэгтгэн бүрэн дунд боловсролын үнэмлэх, суурь боловсролын гэрчилгээний захиалгыг БСШУСЯ-д хүргүүлсэн.		
5	Аймгийн төвийн ЕБСургуулиудын 12 дугаар анги төгсөх сурагчидтай уулзалт зохион байгуулж мэргэжил сонголттой холбоотой мэдээлэл өгсөн.		
6	Норвегийн тусламжийн байгууллагын ажлын хэсэгтэй хамтран Баяннуур сумын Цагаанарал, Дэлүүн сумын		

	Болашах, Тавансалаа бага сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.		
7	Гадаад хэлний багш нарын “Сайн хичээл-Миний туршлага” сэдэвт үйл ажиллагаа 5-р бүрэн дунд сургуульд зохион байгуулагдаж, нийт 25 багш хамрагдан харилцан туршлага солилцсон.		
8	Ховд аймагт зохион байгуулагдсан “Сургалтын байгууллагын орчны стандарт” сэдэвт сургалтанд БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарын бүрэлдэхүүнтэй 5 хүн оролцож харилцан туршлага судалсан.		